

Хичээл үүсгэх

Хичээлийн бизнес процесс

Сургалтын байгууллага нь хэрэгжүүлэх хичээлийн үйлдлийг сургалтын агуулга модуль дээр хийнэ. Энд дараах процесс, дүрмийг харуулсан.


Үүнд:

- Хичээл үүсгэх
- Хичээл засах
- Хичээл устгах

Хичээл үүсгэх

Сургалтын байгууллага нь боловсруулж, баталсан хичээл тус бүрийг давхцахгүй байдлаар системд бүртгэнэ. Шинэ агуулга, индекстэй хичээл батлагдах бүрт системд нэмж үүсгэх үйлдэл хийнэ. Сургалтын агуулга цэс ний хичээл хэсэгт үүсгэсэн нийт хичээл нь сургалтын төлөвлөгөөний бүтэц үүсгэх, суралцагчийн хичээлийн дүн оруулах зэрэгт ашиглагдана.

ПРОЦЕССИЙН НЭР: Хичээл үүсгэх
 ТОДОРХОЙЛОЛТ: Хичээл шинээр бүртгэх ү/а
 ХУВИЛБАР: 1



Тайлбар:

ДБСБ нь шинээр агуулга боловсруулж, батлах үед болон нийт хичээл тус бүрийг системд бүртгэнэ.

ДБУМС нь хичээл үүсгэж, хадгалах үед хичээлийн нэр, индекс давхцаж байгаа эсэхийг шалгаж давхцаж байгаа тохиолдолд анхааруулах мэдээлэл өгнө. Хичээлийн нэр, индекс давхцаагүй үед үүсгэсэн хичээл жагсаалтад нэмэгдэнэ.

БШУЯ сургалтын байгууллага тус бүр дээр үүсгэсэн хичээлийн жагсаалтыг нэгтгэж харах, хянах самбар харах, дата анализ хийх боломжтой байна.


Хичээл засах

Хичээл засах

Хичээлийн дэлгэрэнгүй бүртгэлийн мэдээлэл алдаатай, буруу тохиолдолд хичээл засах үйлдлээр орж мэдээллийг залруулна. Мөн төлөвлөгөөний бүтэц, суралцагчийн дүн зэргийн бүртгэлд ашигласан боловч

ашиглахаа болих тушаал, шийдвэр гарсан хичээлийг хичээл засах үйлдлээр орж төлөвийг идэвхгүй төлөвт шилжүүлнэ. Хичээл засах үйлдлээр ороход судлагдахуун, хичээлийн улирал гэсэн хоёр талбараас бусад талбаруудын утгыг засах боломжтой байна.

ПРОЦЕССИЙН НЭР: Хичээл засах
ТОДОРХОЙЛОЛТ: Хичээлийн мэдээлэл засах ү/а
ХУВИЛБАР: 1



Тайлбар:

ДБСБ нь хичээлийн мэдээлэл алдаатай бүртгэсэн, төлөв өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд хичээл засах үйлдэл хийнэ.

ДБУМС нь хичээл засах үед судлагдахуун, улирлын төрөл талбарын утгыг засах боломжгүй болгоно.


Залруулга хийсэн мэдээллийг ДБСБ, БШУЯ нэгтгэл, жагсаалт, хянах самбараар харах боломжтой байна.

Хичээл устгах

Хичээл устгах

Хичээлийг алдаатай, буруу үүсгэсэн тохиолдолд хичээл устгах үйлдэл хийнэ. Мөн төлөвлөгөөний бүтэц, суралцагчийн дүн зэргийн бүртгэлд ашигласан боловч ашиглахаа болих тушаал, шийдвэр гарсан хичээлийг

устгах боломжгүй бөгөөд хичээл засах үйлдлээр орж төлөвийг идэвхгүй төлөвт шилжүүлнэ.



Тайлбар:

ДБСБ нь хичээл буруу бүртгэсэн тохиолдолд хичээл устгах үйлдэл хийнэ.

ДБУМС нь хичээл устгах үед төлөвлөгөөний бүтэц, суралцагчийн дүнгийн бүртгэлд ашиглагдсан эсэхийг шалгаж устгах боломжтой эсэхийг мэдээлнэ.

Залруулга хийсэн мэдээллийг ДБСБ, БШУЯ нэгтгэл, жагсаалт, хянах самбараар харах боломжтой байна.